



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/04

Чингис хот

Б.Чүнсрийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.3, 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.9, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол, Онцгой комиссын 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аюулгүйн нөөцийн өвсний фондын сахиулаар Банзрагч овогтой Чүнсрийг 2020 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Чүнсрийн цалингийн ангилал зэрэглэлийг ТҮ-1.5 дахь шатлалаар тооцож олгохыг зөвшөөрсүгэй.

3. Цалингийн зардалд 6280860 /зургаан сая хоёр зуун наян мянга найман зуун жаран/ төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 785108 /долоон зуун наян таван мянга нэг зуун найман/ төгрөг бүгд 7065968 /долоон сая жаран таван мянган есөн зуун жаран найман/ төгрөгийг Малыг эрсдэлээс хамгаалах сангаас санхүүжүүлж, Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Нямдаваа/-т, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т, хөдөлмөрийн гэрээ байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар /Н.Чанцал/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА